


БАТЛАВ.СҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГА З.БАЯРСАЙХАН



“Адуучин” тэмцээний удирдамж

Зорилго: Үндэсний соёл, ёс заншлаа хадгалан хамгаалж, хөгжүүлэх, монгол хүний хайрладаг молор эрдэнэ морио зөв хайрлан хамгаалах, эртнээс уламжлан ирсэн уг тэмцээнийг өргөжүүлэн хөгжүүлэх, адуучин залуусынхаа авхаалж самбааг шалгах, уран уургач бугуйлчдынхаа ур ухааныг залуустаа өвлүүлэн үлдээхэд оршино.

Зорилт: Уг тэмцээний хамрах хүрээг өргөжүүлэх, цаашид төрөл болон хэлбэрийг нь олшруулан иргэдийн санал хүсэлтийг нэмэгдүүлэн чанарыг нь дээшлүүлэн хөгжүүлэх зорилготой.

Зохион байгуулагдах үйл ажиллагаа: Адуучин тэмцээн, хурдан морины уралдаан /Соёолон нас/, хүчит бөхийн барилдаан, уралдаан тэмцээнүүд.

Удирдлага зохион байгуулалт: Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар

Хамрах хүрээ: Хөдөөгийн малчин иргэд

Бүртгэл: Сүмбэр сумын “Адуучин” тэмцээний ажлын хэсэг 2016 оны 07 сарын 08-нд 08.00 цагаас тэмцээн болох газарт бүртгэлийг явуулна.

Хугацаа: 2016 оны 07 сарын 08-нд

Зохион байгуулах газар: Сүмбэр сумын 4-р багийн Гашуунд

Тавигдах шаардлага: Морь уургалах тэмцээнд оролцогсод өөрсдийнхөө уурга, бугуйл, уургийн морьтой ирэх, чөдөр зангидах, жирэм сүлжих тэмцээнд оролцох иргэд чөдөр зангидах суртай ирэх. Үндэсний хувцсаа өмссөн байна. Цахим үнэмлэхтэйгээ ирнэ.

Шагнал урамшил: 1-р байр өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байр өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр өргөмжлөл, мөнгөн шагнал

Уралдааныг дүгнэх: Зохион байгуулах ажлын хэсэг.

Удирдамж боловсруулсан:

A handwritten signature in black ink, appearing to be 'B. Uransanaa'.

Б.Урансанаа